ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын 3 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2025/025/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2025 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Б.Бадамцэцэг<br>Утас:99062042<br>Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.25 № 2/61

танай ____________-ны №____________-т

ЖАРГАЛАНТ СУМЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Л.ЧУЛУУНБААТАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 3 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 45 дугаар зүйлийн 45.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Заалны орлогыг байгууллагын дансаар дамжуулан зарцуулаагүй, хувийн харилцах дансаар дамжуулан зарцуулсан 2,176.0 мянган төгрөг;
- Сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдэл 10,210.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй;
- Албан хаагчдийн үр дүнгийн урамшууллыг журамд заасны дагуу олгоогүй 1083.2 мянган төгрөг;

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн, улсын төсвөөс 3,200,909.1 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч гүйцэтгэлийн үнэлгээнд 56 багшаас 4 багш нь 1-р, 11 багш 2-р, 11 багш 3-р, 16 багш 4-р түвшинд үнэлэгдсэн байна.

БШУГ-аас 180,761.9 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар хүлээн авч данс бүртгэл тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 88,409.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,470,000.00 | 7,877,400.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 131,349,220.76 | 180,761,944.00 |
| 120009 | Бусад орлого | 2,742,548.00 | 72,488,150.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | - | 13,543,912.20 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 13,543,912.20 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,565,938,500.00** | **3,619,274,869.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,253,427,900.00 | 3,200,909,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,253,427,900.00 | 3,200,909,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 312,510,600.00 | 417,522,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 312,510,600.00 | 417,522,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 843,269.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 843,269.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,613,619,558.69** | **3,789,179,846.57** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,613,619,558.69** | **3,789,179,846.57** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,481,103,871.22 | 3,572,375,323.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,698,442,060.00 | 2,445,407,498.55 |
| 210101 | Үндсэн цалин | 1,460,555,505.00 | 2,143,255,415.55 |
| 210102 | Нэмэгдэл | 131,217,495.00 | 161,533,223.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 45,600,000.00 | - |
| 210104 | Урамшуулал | 61,069,060.00 | 140,618,860.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 210,500,444.67 | 300,788,277.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 145,644,197.14 | 208,509,321.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,126,523.19 | 24,581,841.50 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,688,018.55 | 12,525,695.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,267,873.69 | 11,034,283.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 30,773,832.10 | 44,137,134.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 308,342,513.53 | 391,365,950.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,306,313.53 | 16,818,490.70 |
| 210302 | Түлш, халаалт | 254,172,600.00 | 325,316,416.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 43,863,600.00 | 49,231,044.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,084,527.00 | 2,930,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 2,930,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,084,527.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | - | 6,702,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 6,702,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,167,500.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,167,500.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,951,900.00 | 48,159,670.17 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,796,900.00 | 2,400,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,155,000.00 | 45,759,670.17 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 227,614,926.02 | 377,021,226.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,850,247.00 | 123,893,279.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,234,700.00 | 24,674,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 162,529,979.02 | 228,453,547.12 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 132,515,687.47 | 216,804,523.30 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 132,515,101.00 | 214,847,974.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 132,515,101.00 | 187,050,274.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 27,797,700.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 586.47 | 1,956,549.30 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 586.47 | 1,956,549.30 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **92,880,710.07** | **104,766,428.63** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 0.64 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 0.64 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (0.64) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **92,880,710.07** | **104,766,427.99** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,575,151,048.00** | **3,699,640,419.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,212,548.00** | **80,365,550.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 9,212,548.00 | 80,365,550.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,470,000.00 | 7,877,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,470,000.00 | 7,877,400.00 |
| 120009 | Бусад орлого | 2,742,548.00 | 72,488,150.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,565,938,500.00** | **3,619,274,869.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,253,427,900.00 | 3,200,909,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,253,427,900.00 | 3,200,909,100.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 312,510,600.00 | 417,522,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 312,510,600.00 | 417,522,500.00 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 843,269.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 843,269.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,490,189,044.67** | **3,647,732,630.45** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,490,189,044.67** | **3,647,732,630.45** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,355,034,598.20** | **3,461,025,606.15** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,700,216,503.83 | 2,443,645,380.59 |
| 210101 | Үндсэн цалин | 1,112,038,194.34 | 1,613,332,280.59 |
| 210102 | Нэмэгдэл | 479,005,652.00 | 724,675,700.00 |
| 210104 | Урамшуулал | 109,172,657.49 | 105,637,400.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 208,726,000.84 | 301,901,164.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 144,147,491.09 | 207,853,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,143,023.19 | 24,453,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,661,618.55 | 12,226,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,103,335.91 | 12,181,878.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 30,670,532.10 | 45,185,586.56 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 308,342,513.53 | 391,365,950.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,306,313.53 | 15,341,557.76 |
| 210302 | Түлш, халаалт | 254,172,600.00 | 326,793,348.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 43,863,600.00 | 49,231,044.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,167,500.00 | 24,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,167,500.00 | 24,200,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,982,134.00 | 82,813,470.17 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,796,900.00 | 30,123,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,185,234.00 | 52,689,670.17 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 120,599,946.00 | 217,099,640.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,904,246.00 | 191,440,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,695,700.00 | 25,659,400.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **135,154,446.47** | **186,707,024.30** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 135,153,860.00 | 184,750,475.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 135,153,860.00 | 156,952,775.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 27,797,700.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 586.47 | 1,956,549.30 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 586.47 | 1,956,549.30 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **84,962,003.33** | **51,907,788.55** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 84,962,003.33 | 51,907,788.55 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 97,252,801.21 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 97,252,801.21 | 149,160,589.76 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,089,808,461.00 | 887,207,173.72 | (377,123,782.79) | 1,599,891,851.93 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,089,808,461.00** | **887,207,173.72** | **(377,123,782.79)** | 1,599,891,851.93 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 208,093,528.57 | 208,093,528.57 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,089,808,461.00** | **887,207,173.72** | **(169,030,254.22)** | 1,807,985,380.50 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,089,808,461.00** | **887,207,173.72** | **(169,030,254.22)** | 1,807,985,380.50 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,089,808,461.00** | **887,207,173.72** | **(169,030,254.22)** | 1,807,985,380.50 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 104,766,427.99 | 104,766,427.99 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,089,808,461.00** | **887,207,173.72** | **(64,263,826.23)** | 1,912,751,808.49 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,805,913,000.00 | 3,644,932,812.15 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,805,913,000.00 | 3,644,932,812.15 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,608,354,700.00 | 3,460,182,337.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,523,214,500.00 | 2,442,727,289.72 |
| 210101 | Үндсэн цалин | 1,692,901,400.00 | 1,597,715,993.97 |
| 210102 | Нэмэгдэл | 724,675,700.00 | 732,451,165.75 |
| 210104 | Урамшуулал | 105,637,400.00 | 112,560,130.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 315,401,900.00 | 301,945,986.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 214,473,300.00 | 207,853,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,232,100.00 | 24,453,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,616,100.00 | 12,226,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,616,100.00 | 12,226,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 50,464,300.00 | 45,185,586.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 393,322,500.00 | 391,365,950.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,221,300.00 | 16,822,006.70 |
| 210302 | Түлш, халаалт | 325,312,900.00 | 325,312,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,788,300.00 | 49,231,044.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,200,000.00 | 24,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,200,000.00 | 24,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 112,464,900.00 | 90,690,870.17 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 46,360,900.00 | 38,001,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 66,104,000.00 | 52,689,670.17 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 239,750,900.00 | 209,252,240.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 214,091,500.00 | 183,592,840.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,659,400.00 | 25,659,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 197,558,300.00 | 184,750,475.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 197,558,300.00 | 184,750,475.00 |
| 213205 | Тэтгэвэрт гарсан иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 169,760,600.00 | 156,952,775.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 27,797,700.00 | 27,797,700.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,805,913,000.00 | 3,696,840,600.70 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,205,613,300.00 | 3,200,909,100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,205,613,300.00 | 3,200,909,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 417,522,500.00 | 415,565,950.70 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 417,522,500.00 | 415,565,950.70 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 182,777,200.00 | 80,365,550.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,426,500.00 | 7,877,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 79,125,200.00 | 72,488,150.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 95,225,500.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **97,252,801.21** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **149,160,589.76** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 83 | 83 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 55 | 55 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 27 | 27 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 992 | 992 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 992 | 992 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 992 | 992 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,469.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ.

Залруулагдаагүй нийт 13,469.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага хэдий ч илэрсэн заалны орлоготой холбоотой асуудал нь шинж чанарын хувьд материаллаг тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,469.8 мянган төгрөгийн 3 зөрчил[1] илэрснээс, 12,386.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,083.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тайлант онд хэрэглэсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 10,210.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоосон

#### 3.1.2 Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

[1] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

***Илрүүлэлт:*** Тайлант 2,176.0 мянган төгрөгийн заалны орлогыг хувь хүний дансаар дамжуулан авч санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүх орлого" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**3.2.1 Цалингийн бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт: Тайлант онд сургалтын менежер нарт 1,083.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А10/9 тоот тушаалын 10-д "Улс, бүс, олон улсын амжилт гаргасан бол 25 хувийн нэмэгдэл олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж: Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А10/9 тушаалыг баримтлан ажиллаж багш, сургалтын менежер нарын ур чадварыг үнэлж олгож байх*

**3.2.1 Орлогын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт: Байгууллага нь хувь иргэдэд заал түрээслэн мөнгөн орлого бүрдүүлж байгаа ч орлогын тооцоог санхүүгийн тайланд бүртгээгүй, орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй, төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлээгүй* байна.

Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 276 тоот "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам" 3.12. Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана гэсэн заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Сангийн Сайдын 2012 оны 276 тоот тушаалыг баримтлан заалны орлогын тооцоог анхан шатны баримтад үндэслэн хийж, тухай бүр төрийн сангийн дансанд тушааж, заалны орлогод тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## 4.1 *Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*

*/сая төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 3 сургууль | Сүү хөтөлбөрийн хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлээгүй | 1 | 10,2 | 1 | 10,2 | | | | | | |
| 3 сургууль | Заалны орлогыг байгууллагын дансаар дамжуулан зарцуулаагүй | 1 | 2,2 | 1 | 2,2 | | | | | | |
| 3 сургууль | Ур чадварын нэмэгдлийг журамд заасны дагуу бодоогүй | 1 | 1,0 | | | | | 1 | 1,0 | | |
| 3 сургууль | Байгууллага нь хувь иргэдэд заал түрээслэн мөнгөн орлого бүрдүүлж байгаа ч орлогын тооцоог санхүүгийн тайланд бүртгээгүй, орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй, төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | |
| **Нийт дүн** | | **4** | **13,5** | **2** | **12,4** | | | **2** | **1,0** | | |